

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ,  
ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ  
/УЛААНБААТАР/, 1 БАГЦ, БХБЯ-ЗҮ-2017/011 ДУГААРТАЙ АЖИЛ”-ЫН ЗӨВЛӨХ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

Дугаар № 2018/10

2018 оны 1 дүгээр сарын 11-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас **Барилга, хот байгуулалтын яам** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **“Мон-Энержи Консалт” ХХК** (цаашид “зөвлөх” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт №1 -д тодорхойлсон “Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ”-нд заасан зөвлөх үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлэх үүрэгтэй.
2. Зөвлөх нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Захиалагч нь “Нийслэл, аймгийн төвийн орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ /Нийслэл, 21 аймаг” төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжиж буй **Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах /Улаанбаатар/, 1 Багц, БХБЯ-ЗҮ-2017/011** дугаартай зөвлөх үйлчилгээний ажлыг (цаашид “ажил” гэх) **788 000 000 /долоон зуун наян найман сая/** төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
4. Гэрээний нийт дүн: **788 000 000 /долоон зуун наян найман сая/** төгрөг. Үүнээс:

**Техник хяналтын зардал гэрээний үнийн дүнгийн 2 хувь буюу 15 760 000 /арван таван сая долоон зуун жаран мянган / төгрөг.**

Санхүүжилтийн эх үүсвэр: Улсын төсвөөс: 2018 онд 788 000 000 /долоон зуун наян найман сая/ төгрөгөөр санхүүжигдэнэ.

5. Зөвлөх нь **“Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах”** зөвлөх үйлчилгээний ажлыг 2018 оны 01 дугаар сарын 12-ны өдөр эхэлж, 2018 оны 09 дугаар сарын 27-ны өдрийн дотор хүлээлгэж өгнө.
6. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- Үнэлгээний хорооны зөвлөмж
- Гэрээний тусгай нөхцөл
- Гэрээний ерөнхий нөхцөл
- Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар
- Ажил гүйцэтгэх хуваарь
- Санхүүгийн хуваарь
- Гүйцэтгэлийн баталгаа

Гэрээ нь энд дурдсан Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

7. Захиалагч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.